БАТЛАВ
ЕСӨНБУЛАГ СУМЫН ЗАСАГ

ДАРГА Д.ЧИНЗОРИГ

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ЕСӨНБУЛАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

АЛТАЙ ХОТЫН НИЙТИЙН ЭЗЭМШЛИЙН ТАЛБАЙ, ТУСГАЙ ЗОРИУЛАЛТЫН ОБЪЕКТЫГ ТЕЛЕКАМЕРЫН ХЯНАЛТЫН СИСТЕМТЭЙ БОЛГОХ АЖЛЫГ ГҮЙЦЭТГҮҮЛЭХ ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ

Тендер шалгаруулалт/ гэрээний нэр:	Алтай хотын нийтийн эзэмшлийн талбай, тусгай зориулалтын объектыг телекамерын хяналтын системтэй болгох
Тендер шалгаруулалт/ гэрээний дугаар:	ГААЕБСЗДТГ/202101001

Алтай хот 2021 он

Нэг. **ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА**

2021.06.17

[Говь-Алтай аймгийн* Есөнбулаг сумын Засаг даргын тамгын газар*] нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос ***[Алтай хотын нийтийн эзэмшлийн талбай, тусгай зориулалтын объектыг телекамерын хяналтын системтэй болгох ГААЕБСЗДТГ/202101001]***–ыг гүйцэтгэх тухай ажилд үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн санал ирүүлэх ажлын зураг, техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Энэхүү ажлын тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа цахим тендер тул www.tender.gov.mn хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг татаж авна уу.

Тендерт оролцогч нь тендерийн баримт бичгийг илгээхийн өмнө **50 000 (тавин мянга)** төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байх ёстой.

Үнийн саналыг ***[2021 оны 07 дугаар сарын 19-ны өдрийн 11:00 цаг]-***аас өмнө ***[Цахимаар]*** хаягаар ирүүлнэ.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан ***[2021 оны 07 дугаар сарын 19]***-ны өдрийн ***[11:30 цаг]***[1]-т нээнэ.

Дотоодын давуу эрх тооцох эсэх. Үгүй

Сонирхсон этгээд Үнийн санал авах баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Монгол, Говь-Алтай аймаг,
Есөнбулаг сум, Индэрт баг
Есөнбулаг сумын ЗДТГ-ын байр
Утас: 70483784

Хоёр. **ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА**

1. Эрх бүхий тендерт оролцогч

1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.

2. **Тендер ирүүлэх, тендерийн нээлт**

2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.

2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.

3. Тендерийн иж бүрдэл

3.1. Тендерт оролцогчдод өгсөн зааварчилгааны дагуу бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ:

(а) Үнийн санал;
(б) Үнэлэгдсэн үе шатны ажлын хуваарь;
(в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
(г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
(д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]

4. Тендерийн үнэ

4.1. Тендерийн үнэд тодорхойлсон нийт ажил хамрах ба тендерт оролцогчийн үнэлж ирүүлсэн үе шатны ажлын хуваарьт үндэслэнэ.

4.2. Тендерт оролцогч үнийн хөнгөлөлтийг тендерт тусган санал болгож болно.

4.3. Тендерт оролцогч нь зураг болон техникийн тодорхойлолтод тодорхойлогдсон ажлыг үнэлэхдээ үе шатны ажлын хуваарьт хураангуй байдлаар өгөгдсөн бүх нэр төрөлд нэгж үнэ болон нийт үнэ санал болгоно. Тендерт оролцогч аль нэг нэр төрлийн нэгж үнэ болон нийт үнийг бөглөөгүй орхисон тохиолдолд түүнийг гүйцэтгэсний төлбөрийг захиалагч хийхгүй ба бусад нэр төрлийн үнэд багтсан гэж үзнэ.

4.4. Тендерт оролцогч нь тендер хүлээн авах эцсийн хугацаанаас 14 хоногийн өмнө хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн дагуу энэ гэрээ болон бусад үндэслэлээр гүйцэтгэгчийн төлөх ёстой бүх татвар, хураамж, бусад төлбөрийг тендерийн нийт үнэд багтаасан байна.

5. Үнийн саналын хүчинтэй

5.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш ***30*** хоногийн хугацаанд хүчинтэй байна.

байх хугацаа

6. Алдааг залруулах

6.1. Захиалагч шаардлагад нийцсэн тендерийн арифметик алдааг шалгаж дараах байдлаар залруулна:

(а) тоо болон үсгээр илэрхийлэгдсэн дүн хоорондоо зөрсөн бол үсгээр илэрхийлэгдсэнийг зөв гэж үзнэ;

(б) үе шатны ажлын үнийн нийлбэр тендерийн маягтад заасан тендерийн нийт үнээс зөрвөл үе шатны ажлын үнийн нийлбэрийг үндэслэн тендерийн нийт үнийг залруулна;

(в) нэгж үнийг ажлын тоо хэмжээгээр үржүүлж гаргасан нэг мөр дэх нийт дүнд зөрүү гарвал нэгж үнийг давамгайлах гэж үзнэ. Гэхдээ захиалагчийн үзэж байгаагаар нэгж үнэд аравтын орны таслалыг андуурсан болох нь илэрхий байвал тухайн мөр дэх нийт дүнг зөв гэж үзэн холбогдох нэгж үнийг залруулна.

6.2. Захиалагчийн залруулсан тендерийн дүнг тендерт оролцогчийн зөвшөөрлөөр эцсийнх гэж үзнэ. Хэрэв тендерт оролцогч залруулсан дүнг хүлээн зөвшөөрөхгүй бол захиалагч түүний тендерээс татгалзана.

7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх

7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал,татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.

7.2. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдийн үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.

8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл

8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө утсан холбоогоор мэдэгдэж, албан бичгээр баталгаажуулна. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав.**ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ**

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

Тухайн тендер шалгаруулалтын үр дүнд гүйцэтгэх ажлын талаарх дор дурдсан өгөгдөл нь ТОӨЗ-ны холбогдох зүйл, заалтад нэмэлт мэдээлэл оруулах, эсхүл өөрчлөх зорилготой. Хэрэв ТОӨЗ-ны зүйл заалттай зөрчилдвөл энэхүү ТШӨХ-д дурдсан мэдээллийг зөв гэж үзнэ.

ТОӨЗ-ны холбогдох заалт	**А. Ерөнхий зүйл**
ТОӨЗ 1.1	Захиалагч нь: ***Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын Засаг даргын тамгын газар***
ТОӨЗ 1.1	Нээлттэй тендер шалгаруулалтын нэр болон ялгагдах дугаар нь: **Алтай хотын нийтийн эзэмшлийн талбай, тусгай зориулалтын объектыг телекамерын хяналтын системтэй болгох *ГААЕБСЗДТГ/202101001***
ТОӨЗ 1.2	Ажил гүйцэтгэж дуусах хугацаа нь: ***2021.08.20***
ТОӨЗ 1.3	Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: ***багцтай*** ***Багц-1*** **Алтай хотын нийтийн эзэмшлийн талбай, тусгай зориулалтын объектыг телекамерын хяналтын системтэй болгох** **Багц-2 Хаягжуулалт**
ТОӨЗ 2.1	Санхүүжилтийн эх үүсвэр нь: ***Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө*** ***80.000.000 төгрөг***
ТОӨЗ 4.4.(в)	Уг ажлыг гүйцэтгэхэд тусгай зөвшөөрөл зайлшгүй шаардлагатай эсэх: ***"тийм" шаардлагатай тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хуулбар нотариатаар баталгаажуулж ирүүлнэ. /2.2.2 Холбоо дохиолол, интернет сүлжээний ажлын заалттай/***
ТОӨЗ 5.2	Тендерт оролцогч гэрээг хэрэгжүүлэх чадвартайг нотлохын тулд захиалагч дараах нэмэлт нотлох баримтыг тендерийн хамт ирүүлэх: *1.* Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээ *2.* Татварын цахим системийн тодорхойлолт */цахимаар шалгана/, /тендер нээсэн өдрийн байдлаар татварын өргүй байна/*; *3.* Шүүхийн тодорхойлолтыг цахим системээс лавлаж үнэлгээнд харгалзана. *4.* Үнийн санал /маягтын дагуу/, *5.* Ажлын даалгаврын дагуу төсөв хийж ирүүлнэ. Төсвийг Монгол улсад хүчин төгөлдөр хэрэглэж буй төсөв зохиох программаар гүйцэтгэж эрх бүхий төсөвчнөөр баталгаажуулсан байна; *6.* Нийлүүлэгдэх камеруудын марк загвар, сериал дугаараар Интернэтээс хайхад техникийн үзүүлэлт харагдах боломжтой байна; *7.* Сонгосон бараа материал, тоног төхөөрөмжийн үйлдвэрлэгчийн итгэмжлэл, техникийн тодорхойлолт, гэрэл зураг;
ТОӨЗ 5.2.(б)	Санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: **Сүүлийн 2 жил буюу 2019, 2020 оны жилийн эцсийн санхүүгийн мэдээллийг цахим системээс лавлана** Санхүүгийн тайланг аудитаар баталгаажуулсан байх шаардлагатай эсэх: шаардлагагүй
ТОӨЗ 5.2 (г)	Хийж гүйцэтгэсэн ажлын нийт мөнгөн дүнг жил жилээр харуулсан жагсаалт ирүүлэх шаардлагатай жилийн тоо: ***Сүүлийн 2 жил***
ТОӨЗ 5.2 (д)	Ижил төстэй ажил гэрээгээр гүйцэтгэсэн туршлагын талаарх мэдээлэл ирүүлэх жилийн тоо: ***[Сүүлийн 2 жил]***

ТОӨЗ 5.2 (к)	Тендерт оролцогч туслан гүйцэтгэгчээр гүйцэтгүүлж болох хувь хэмжээ нь гэрээний үнийн дүнгийн *10* хүртэл хувь байна.Үүнээс дээш хувийг гуравдагч этгээдээр гүйцэтгүүлэх бол түншлэлийн гэрээ байгуулж тендерийн хамт ирүүлэх ба ТОӨЗ-нд дурдсан бусад шалгуурыг хангасан байх шаардлагатай.
ТОӨЗ 5.3 (а)	Борлуулалтын хэмжээ: ***[сүүлийн 2 жил]*** Борлуулалтын орлогын нийт мөнгөн дүнгийн жилийн дундаж нь ***30,0 сая*-с багагүй байх.**
ТОӨЗ 5.3 (б)	Ижил төстэй ажлыг ядаж нэг удаа гүйцэтгэсэн байвал зохих хугацаа: ***сүүлийн 2 жилийн аль нэг жилд ижил төстэй ажил хийсэн туршлагатай байх.*** ***Ижил төстэй ажил гэдэгт төрөл үнийн дүнгээрээ дүйцэх камержуулалтын ажлыг тооцно.***
ТОӨЗ 5.3 (в)	Тендерт оролцогч гэрээг гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай үндсэн тоног төхөөрөмж, машин механизмууд: Кран-1 /5тн/, шилэн кабелийн залгааны машин-1, зөөврийн тогтмол гүйдлийн хонда мотор-1 /2.2 кВа/, хэмжүүрийн машин, ачааны машин /6тн/, тулгуур ачигч. Бусад шаардлагатай машин механизмын жагсаалтыг батлагдсан маягтын дагуу нотлох баримт гэрчилгээ, гэрэл зургийн хамт ирүүлэх Түрээслэх бол хүчин төгөлдөр түрээсийн гэрээ ирүүлнэ.
ТОӨЗ 5.3 (г)	Ерөнхий инженер нь гэрээнд заасан ажилтай төрөл, үнийн дүнгээрээ дүйцэх ажил дээр ажилласан туршлагатай байх хугацаа: ***5 жил*** Түүний дотроос гэрээг хариуцаж ажилласан туршлагатай байх хугацаа: ***1 жил*** ***Холбооны инженер, цахилгааны инженер, сүлжээний инженер, кабельчин гэх мэт ИТА болон мэргэжилтэй ажилчдын жагсаалтыг нотлох баримт, диплом гэрчилгээний хамт ирүүлнэ.***
ТОӨЗ 5.3 (д)	Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн нийт дүн: **24*,0 сая төгрөг***
	В. Тендер бэлтгэх
ТОӨЗ 13.1	тендерт гадаадын этгээд оролцох эрхгүй
ТОӨЗ 14.1 (ж)	Тендерт оролцогч дараах нэмэлт материалуудыг өөрийн тендерт ирүүлнэ.Үүнд: 1. Үе шатны ажлын хуваарь
ТОӨЗ 16.1	Хувилбарт тендер ирүүлэхийг ***"зөвшөөрөхгүй"***
ТОӨЗ 17.8	Тендерт оролцогчийн санал болгосон үнийг гэрээний хэрэгжилтийн явцад ***"тохируулахгүй тогтмол байна."***
ТОӨЗ 18.1	Тендерийн валют: ***[Төгрөг байна.]***
ТОӨЗ 20.1	Тендер нээснээс хойш ***30*** хоногийн туршид хүчинтэй байна.
ТОӨЗ 21	Тендерийн баталгааны үнийн дүн: ***800.000 төгрөг*** Хүчинтэй байх хугацаа***: 2021 оны 9 сарын 14 өдрийг дуустал***
ТОӨЗ 22.1	Тендерийн эх хувиас гадна ирүүлэх хуулбар хувийн тоо: ***хуулбар хувь шаардлагагүй.***
	Г. Тендер ирүүлэх

ТОӨЗ 23.3 (б)	Захиалагч тендерүүдийг хүлээн авах хаяг нь: Тендер хүлээн авах этгээд: ***Захирагчийн ажлын албаны мэргэжилтэн*** Байгууллагын хаяг: ***Есөнбулаг сумын Засаг даргын тамгын газар*** Давхар болон өрөөний дугаар: ***2 давхар 207 toot*** Аймаг, хот: ***Говь-Алтай аймаг Есөнбулаг сум*** Улс: ***Монгол Улс***
ТОӨЗ 24.1	Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь: Огноо: ***2021 оны 7 сарын 19*** Цаг: ***11:00***
Д. Тендерийг нээх, үнэлэх	
ТОӨЗ 27.1	Тендерийн нээлт хийх газрын хаяг нь дор өгөгдөв. Үүнд: Байшин, гудамжны нэр: ***Есөнбулаг сумын Засаг даргын тамгын газар*** Давхар болон өрөөний дугаар: ***ЗТДГ-ын байр 2 давхар 207 toot*** Аймаг, хот: ***Говь-Алтай аймаг Есөнбулаг сум*** Улс: ***Монгол Улс*** Тендерийн нээлт хийх огноо, цаг нь: Огноо: ***2021 оны 7 сарын 19*** Цаг: ***11:30***
ТОӨЗ 33.1	Дотоодын давуу эрхийн зөрүү: ***“тооцохгүй”***
ТОӨЗ 34.4	Тендерийн үнэлгээнд үнээс гадна дараах хүчин зүйлсийг харгалзана. Үүнд: (а) Гэрээний болон арилжааны зөрүү: ***“Ашиглахгүй”*** (б) Ажлын гүйцэтгэлийн хугацааг зөрүүтэй тогтоох: ***“Ашиглахгүй”*** (в) Төлбөрийн хуваарийн зөрүү:***[“Ашиглана” эсхүл “Ашиглахгүй”*** *Үнэлгээнд харгалзах сарын дундаж хүүгийн хувиар илэрхийлэгдсэн хэмжээ: [тоо оруул]*

Дөрөв. **ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ-1**

/Антеннтэй хяналтын камер суурилуулах ажил/

1. ТЕХНИКИЙН ЕРӨНХИЙ ШААРДЛАГА.

1.1. Монгол улсын **MNS 6423:2013** стандартыг мөрдлөг болгоно.

1.2. **Телех-хяналтын систем нь:** Дараах бүтэцтэй байна.

a. Телекамер;
b. Бичлэг хадгалах төхөөрөмж;
c. Бичлэгийн програм хангамж;
d. Бичлэг хадгалагч төхөөрөмжийг байршуулагдах зориулалтын өрөө;
e. Хяналтын дэлгэц;
f. Сүлжээний төхөөрөмжүүд;
g. Цахилгаан тэжээлийн төхөөрөмж;
h. Сүлжээний болон цахилгааны холболт зэргээс бүрдэнэ.

1.3. Телехяналтын системд ашиглагдаж байгаа техник хэрэгслийн баталгаат хугацаа 3 жилээс багагүй байх.

1.4. Програм хангамж нь хамгийн багадаа 3 жилээс багагүй хугацааны лицензтэй байх. Лицензийн хугацаанд программын шинэ болон сайжруулсан хувилбарыг үнэ төлбөргүй авах, /үйлдвэрлэгчээс Монгол дахь борлуулагчаар дамжихгүйгээр шууд дэмжлэг авах зардал орно/.

1.5. Камерын системд гадна ажиллах бүхий л тоноглол нь Монгол орны цаг уур, орчинд тохирсон (-)40С – (+)50С ажилладаг, чийгшилт, тоосжилтын хамгаалалттай байна.

1.6. Угсралт монтажын ажлыг холбогдох стандарт шаардлагын дагуу чанарын өндөр түвшинд гүйцэтгэсэн байна.

1.7. Гарын авлага:

a. Телехяналтын системийн хэрэглэгчийн болон ашиглалтын заавар нь Монгол хэл дээр цаасан болон цахим хэлбэрээр байх;
b. Техникийн тодорхойлолт Англи хэл дээр байж болно.

2. СҮЛЖЭЭНИЙ ХОЛБОЛТ:

2.1. Хяналтын камерын системийн сүлжээг шаардлага, техникийн нөхцөлийн дагуу зохион байгуулах бөгөөд сүлжээг тухайн нутаг дэвсгэрийн Алтай хотын Тохижилт үйлчилгээний газар дээр төвлөрүүлэхээр зохион байгуулна.

2.2. Сүлжээг Wireless сүлжээгээр холбосон байна.

3. СҮЛЖЭЭНИЙ ШААРДЛАГА:

3.1. Сүлжээний үндсэн төхөөрөмжүүд нь Gigabit Ethernet сүлжээний төхөөрөмж байна. Шилэн кабелын интерфейс нь 1 Гбит/сек багагүй байна.

3.2. Сүлжээний хамгаалалтын түвшинг нэмэгдүүлэх WLAN үүсгэх L2 түвшний төхөөрөмжүүд байна.

3.3. Сүлжээний зангилаа /серверийн өрөөнд/-ын өрөөнд төвлөрсөн байна.

3.4. Үндсэн сүлжээний төхөөрөмжүүдийг redundancy /Rack mount ,Patch Panel/ байдлаар зохион байгуулах;

3.5. Сүлжээний төхөөрөмжүүд нь тухайн сүлжээний хяналтын камерын урсгалыг даахуйц үзүүлэлттэй, тасалдалгүй дамжуулдаг байх;

3.6. Сүлжээний дэд бүтэц байгуулах төлөвлөгөө, шийдлийг боловсруулж инженерийн дэлгэрэнгүй зураг, тайлбартай гаргасан байна.

4. ТЕЛЕХЯНАЛТЫН СИСТЕМИЙН ШУГАМЫН МОНТАЖ, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ХОЛБОЛТ, УГСРАЛТ СУУРИЛУУЛАЛТ

4.1. Угсралт, суурилуулалтын ерөнхий шаардлага

Хяналтын системийн дүрсний, тэжээлийн, удирдлагын, сүлжээний зэрэг

холболтын кабель, шугамын монтажийг барилга дотор болон гадна татагдахаас хамаарч дараах байдлаар хийнэ. Үүнд:

4.1.1. Камерын сүлжээг Монгол Улсын MNS:5207:2011стандартын дагуу хийж гүйцэтгэх.

4.1.2. Барилга доорхи монтажийг кабель далдлагч ашиглах бөгөөд кабелийн тоо хэмжээнээс хамаарч далдлагчийн хэмжээ багтаамжийг сонгох.

4.1.3. Далдлагчийг тухайн барилгын хийц, онцлог, зохион байгуулалтаас хамаарч хана болон таазанд суурилуулах;

4.1.4. Гадаа татагдах кабель шугамыг уян хоолойгоор далдлаж, газраас дээш 3 метрээс доошгүй өндөрт бэхэлсэн байх, энэ үед кабелийн өнгө үзэмжийг анхаарч бэхэлгээг хийх шаардлагатай. Бэхэлгээ хийхэд хамгаалалтын хоолойн зориулалтын тогтоогчийг ашиглах;

4.1.5. Агаараар татах тохиолдолд кабель шугамыг багцалж, уян ган /тросс/ утсанд бэхэлнэ. Уян ган /тросс/ утасны төгсгөлийг газардуулсан байна;

4.1.6. Камер, шонг хаягжуулсан байна. Дугаарлалт, схемчилсэн зургийг ажил гүйцэтгэсэн баримтанд хавсаргасан байх.

4.1.7. Хяналтын цэгийн техник хэрэгсэл /FDF, media convertor, switch, тэжээлийн залгуур, хүчдэл тогтворжуулагч гэх мэт /-ийн холболтуудыг хийх хайрцагтай байх ба энэхүү хайрцаг нь гадны халдлагад өртөхөөргүй газарт байрлана;

4.1.8. Хайрцагны гадна талд таних тэмдэг, дугаарлалт, санамж анхааруулга дотор талд нь техник хэрэгслүүдийн холболтын схем зураглал, зааварчилгаа зэргийг ил харагдах байдлаар хийж өгнө.

4.1.9. Хайрцаг зэврэлтээс хамгаалсан цайран түрхэцтэй, тоос шороо үл нэвтрэх, ус чийгний хамгаалалттай байх;

4.1.10. Хайрцагт цахилгааны болон сүлжээний төхөөрөмжүүд ажиллагааны хэвийн орчинг бүрдүүлэх халаагч, хөргүүр байрлуулах;

4.1.11. Дээрх нөхцлөөс 2-3 нөхцлийн хангаагүй тохиодолд дахин хугацаа төлөвлөж ажлын гүйцэтгэлийг биелэлт хүртэл хангана;

4.1.12. Гэрээнд ажил дуусгавар болгох хугацааг эцэслэн тодорхой зааж өгөх;

4.2. Телекамерыг багана, барилгын хана, дээвэр дээр суурилуулах шаардлага:

4.2.1. Хяналтын цэг тус бүрт 1-2 камер суурилуулах боломжтойгоор зохион байгуулах

4.2.2. Баганы өндөр тухайн байрлалд тавигдсан шаардлагын дагуу 6 – 10 метр байх;

4.2.3. Барилга байгууламжийн дээвэр дээр хяналтын камер суурилуулсан тохиолдолд хананаас 2 метрээс багагүй зайнд байрлуулах;

4.2.4. Аянга хамгаалагч газардуулагатай байх;

4.2.5. Кабель монтажийн ажил бүгд далд (шон дотуур) байна.

4.3. Цахилгаан тэжээлийн шаардлага:

4.3.1. Телехяналтын системийн бүх тоног төхөөрөмжүүд нь 220/240VAC 50 Hz, нэг-фазын цахилгаан тэжээлээр ажиллана;

4.3.2. Тэжээлийн кабелийн төрөл, хөндлөн огтлолыг хэрэглэх чадлаас хамааруулан тухайн суурьлуулалтыг гүйцэтгэж байгаа ахлах инженер сонгоно.

4.3.3. Төв серверийн өрөө, дэд хяналтын төвүүдийн тоног төхөөрөмж нь нөөц цахилгаан тэжээл тог тогтворжуулагч, тог баригч /2 доошгүй цаг барих//UPS/-тэй байх;

4.3.4. Хяналтын цэгийн камеруудыг цахилгааны хэлбэлзлээс хамгаалах хүчдэл тогтворжуулагчтай байх.

5. ТЕЛЕКАМЕРЫН ТЕХНИКИЙН ШААРДЛАГА

5.1. <u>Камерын үндсэн шаардлага</u>

5.1.1. Хяналтын камер нь олон улсын стандартад нийцсэн, дэлхийд хүлээн зөвшөөрөгдсөн бүтээгдэхүүн байна;

5.1.2. Тоон технологи дээр суурилсан байх;

5.1.3. Хяналтын цэгийн байрлал тухайн орчны гэрэлтүүлэг, онцлог байдлаас хамаарч хөдөлгөөнт эргэдэг /Pan-Tilt/, татдаг /Zoom/ камертай бусад төрлийн камеруудыг хосолсон байдлаар суурилуулна;

5.1.4. Олон улсын сүлжээний хяналтын камерын нэгдсэн стандарт болох ONVIF стандартыг дэмждэг байх.

5.1.5. Ус чийг, тоос, шороо, доргилтоос хамгаалагдсан IP66 болон NEMA 4X rated, IK-10 зэрэг олон улсын стандарт шаардлагуудыг заавал хангасан байх.

5.1.6. 6 болон түүнээс дээш зэрэг урсгалыг дамжуулах чадвартай байх.

5.1.7. 10-аас доошгүй тооны хэрэглэгч зэрэг хандах боломжтой байх.

5.1.8. Камерийн хяналтын төвийн үйл ажиллагаа тасалдах, камерийн сүлжээ тасрах эсвэл бичигч ажиллахгүй болсон үед камер нь өөрийн 64GB SDXC дээр бичлэгийг хадгалж, сүлжээ эргэж сэргэхэд бичлэгийг автоматаар /операторын дэмжлэггүйгээр/ төв серверт /бичигчид/ дамжуулдаг байх;

5.1.9. Хяналтын цэгийн байрлал тухайн орчны гэрэлтүүлэг, онцлог байдлаас хамаарч маш бага гэрлийн орчинд дүрсний чанар өндөртэй, хөдөлгөөнт эргэдэг татдаг камертай бусад төрлийн камеруудыг хосолсон байдлаар суурилуулж болно.

5.1.10. Дүрс хувиргаж сүлжээнд дамжуулах шахалтын горим нь лицензтэй H.265,IR5, (ISO/IEC 14496-10), Motion JPEG (M-JPEG) байх;

5.1.11. IPv4/v6, HTTP, HTTPS, QoS болон бусад сүлжээний протоколуудыг дэмжиж ажилладаг байх;

5.1.12. Сүлжээгээр цахилгаан тэжээл (HighPoE -IEEE 802.3at) авдаг байх;

5.2. <u>Хөдөлгөөнт эргэдэг теле камерын шаардлага:</u>

5.2.1. Эргэдэг татдаг камер байх;

5.2.2. Оптик таталт 30х, тоон таталт 12х, таталтын нийт хэмжээ 360х дахин (түүнээс дээш) байх;

5.2.3. Дүрсний хэмжээс, нягтрал: 1280x720, HD 720p ба түүнээс дээш байх;

5.2.4. Нэг секундэд авах кадрын тоо нь дүрсний бүх хэмжээсд 25-30 кадр байх;

5.2.5. Хамгийн багадаа 4ш бие даасан H.265 урсгалтай байх бөгөөд дараах зориулалтаар тус бүрийн хэрэглээний онцлогт нь тааруулж тохируулах боломжтой байх. (Оператор, Бичлэгийн сервер, SDXC Нөөц бичлэг, Зайн хандалт болон бусад хэрэглээ.)

5.2.6. Хэт улаан гэрэл (IR-Infra Red) дэмждэг, линзэндээ хэт улаан гэрлийн автомат хөшигтэй байх;

5.2.7. Араас туссан шууд гэрлийн нөлөөний эсрэг функцтэй байх - /Wide Dynamic Range picture, Wide Dynamic Range contrast/,

5.2.8. Ажиллах хамгийн бага гэрлийн орчин нь: Хар цагаан горимд – 0.01 люкс, өнгөт горимд – 0.1 люкс;

5.2.9. Хүйтний улиралд цахилгааны саатлаас болж төхөөрөмж хөлдөх эрсдэлтэй. Цахилгаан сэргэхэд камер өөрийгөө хэвийн ажиллах температур хүртэл халаасны дараа асдаг байх;

5.2.10. Байгалийн гэрлийн орчинд тохирч ажиллах, өдөр шөнийн автомат функцтэй байх

5.2.11. Харанхуй орчинд дүрсийг сайн таних, хөдөлгөөнд ямар нэгэн сарнил (30 кадраас буухгүй) байхгүй байх.

5.2.12. Бага гэрлийн орчинд хөдөлгөөнийг мэдэрч ямарч сарнил, гацалт, хөдөлгөөний зууралт үүсэхгүй байна;

5.2.13. Обьектыг өөрөө дагах болон камерт 1 дээш оператор хандсан үед хөдөлгөөний удирдлагыг зохицуулдаг байх

Part	Description	
IR PTZ Camera Outdoor	1/2.8" CMOS WDR, 25X zoom, IR 100m, IP66 waterproof, -50C/+70C	21
Wireless Link Outdoor	IP65 protection, PoE support, Hide SSID, Qualcomm Chip -50C/+70C	3
Wireless bridge	802.11n, 1 x10/100Mbps, 5G, PoE 15-24V -50C/+70C	22
PoE Switch	Gigabit PoE Switch, 10 Gigabit Switch outdoor -50C/+70C	1
Camera pole	Galvanization, 5-meter single pole	6
Camera pole	Galvanization, 8-meter single pole	5
Equipment box	500W*500H*150Dmm, IP66	21
AC cable	2*10 AWG outdoor	500
Display	42" IPS LED Full HD (1080p) 1920 x 1080 at 75 Hz 16:9 with tilt wall mount kit	1
Recorder	32 Channel, PPPoE,DDNS,TCP/IP,DHCP, 4TB, 12MP, 8MP, 6MP, 5MP, 4MP, 3MP, 1080P, 1.3MP, 720P, D1 etc	1

5.3. Чиглэлийн теле камерын шаардлага:

5.3.1. Хөдөлгөөнгүй камер байна;
5.3.2. Дүрсний нягтрал HD1080 ба түүнээс дээш байх;
5.3.3. Секундэд авах кадрын тоо нь дүрсний бүх хэмжээсд 25-30 кадр байна;
5.3.4. Хамгийн багадаа 4ш бие даасан H.265 урсгалтай байх бөгөөд дараах зориулалтаар тус бүрийн хэрэглээний онцлогт нь тааруулж тохируулах боломжтой байх. (Оператор, Бичлэгийн сервер, SDXC Нөөц бичлэг, Зайн хандалт болон бусад хэрэглээ.)
5.3.5. 2.8-8мм эсвэл түүнээс дээш, 800-350 харах чадвартай, автомат DC-Iris, камерын фокусыг хяналтын төвөөс систем дээрээс тохируулдаг байна;
5.3.6. Хэт улаан гэрэл (IR-Infra Red) дэмждэг, линзэндээ хэт улаан гэрлийн автомат хөшигтэй байна;
5.3.7. Харанхуйд хөдөлгөөний зууралтгүй, өнгөтөөр харах камерын урдаас туссан шууд гэрлийн нөлөөний эсрэг функцтэй байх - Wide Dynamic Range
5.3.8. Камерын тусгал, фокус ба чиглэл өөрчлөгдсөн үед автоматаар түгшүүр зарладаг
5.3.9. Нэмэлт микрофон болон чанга яригч холбох боломжтой
5.3.10. Ажиллах гэрлийн орчин нь: Хар цагаан горимд – 0.02 люкс, өнгөт горимд – 0.1 люкс;
5.3.11. Байгалийн гэрлийн орчинд тохирч ажиллах, өдөр шөнийн автомат функцтэй байна.
5.3.12. Харанхуй орчинд дүрсийг өнгөтөөр таних, хөдөлгөөнд ямар нэгэн сарнил (30 кадраас буухгүй) байхгүй байна.
5.3.13. Бага гэрлийн орчинд хөдөлгөөнийг мэдэрч ямарч сарнил, гацалт, хөдөлгөөний зууралт үүсэхгүй байна;

6. ХЯНАЛТЫН ТӨВ

Хяналтын төв нь: байрлах газар нь тухайн нутаг дэвсгэрийн Алтай хотын Тохижилт үйлчилгээний газрын байранд байна. Хяналтын төвд удирдлагын өрөөнөөс сервер, сүлжээний зангилаа төхөөрөмж, серверийн нөөц цахилгаан тэжээл зэрэг тоног төхөөрөмжүүдийг тусгаарлаж хяналтын системийг тасралтгүй хэвийн ажиллах нөхцөлийг бүрдүүлсэн байна.

6.1. Хяналтын төвийн шаардлага

6.1.1. Суурилуулсан бүх теле камеруудыг удирдаж нэгдсэн хяналт хийх

боломжтой байна.

6.1.2. Камерын нэгдсэн системтэй уялдан ажиллах боломжтой байна.

6.1.3. Телехяналтын камерын тоо, өргөтгөх боломжийг тооцоолж операторын ажлын байрыг тодорхойлно.

6.1.4. Ханын дэлгэцийн системтэй байх. Дэлгэц нь 42 инчээс багагүй, хүрээгүй (0,6мм), шууд нийлүүлж нэг том дүрс гаргах зориулалт бүхий тусгай дэлгэц байна.

6.2. <u>Бичлэгийн төхөөрөмж</u>

Нэгдсэн удирдлага менежментын сервертэй байж болно.

6.2.1. Тоо хэмжээ нь: Нэг сервер дээр 32 дээшгүй камерын дүрсийг бичнэ. H.265 дэмжин ажиллана.

6.2.2. Нийт багтаамж нь: Бүх камер хамгийн багадаа 45 хоногийн бичлэгийг дүрсний хамгийн дээд хэмжээсээр хадгалах боломжтой байна.

6.3. <u>Бичлэгийн програм хангамж</u>

6.3.1. Албан ёсны лизенцтэй програм хангамж байх;

6.3.2. Үнэгүй сайжруулалт /upgrade/ хийх боломжтой байх;

6.3.3. Хяналтын камерын тоог өргөтгөх боломжтой байх;

6.3.4. Видео бичлэгүүдийг сүлжээний доголдол болон серверийн тоног төхөөрөмжийн эвдэрлээс хамгаалах (redundancy) боломжтой байх, улмаар гэмтэл гарсан үед системийг сүлжээгээр зөөх зэрэг боломжтой байх.

6.3.5. Системийн ачаалал болон гэмтэлийг байнгын хянах мониторингийн (system health monitoring) фунцктэй байх.

6.3.6. Сүлжээний ачаалалыг зохицуулж камераас ирж буй сувгуудаг зохицуулалт хийдэг байх.

6.3.7. Операторын дэлгэц дээр нэгэн зэрэг хэдэн камер гарч байгаагаас хамааран автоматаар видео сувгийн дүрсний нягталыг буулгаж болон өсгөдөг байх.

6.3.8. Хяналтын камеруудад байгаа тус бүр 64Гб санах ойтой нэгдэн ажиллаж сүлжээ тасрах эсвэл камерийн хяналтын төвийн үйл ажиллагаа доголдох, бичигч ажиллахгүй болох зэрэг тохиолдолд сүлжээ эргэж сэргэхэд бичлэгийг автоматаар, операторын дэмжлэггүйгээр систем руу нөхөж оруулдаг байх

6.3.9. Бусад бүс болон хотын ижил төрлийн системтэй уялдан ажиллах боломтой байх.

6.3.10. Газрын зураг дээр суурилсан интерфейс заавал байх.

6.3.11. Чанга яригч, зарлан мэдээлэх болон гамшигийн аюулыг нийтэд мэдээллэх системтэй холбогдон ажиллах боломтой байх.

6.3.12. Бичлэгийн програм хангамж нь тээврийн хэрэгслийн улсын дугаар таних системтэй интеграц хийгдэн нэг үндсэн систем болон ажилладаг байна

6.3.13. Серверүүд нь сүлжээний орчинд нэг сервер байдлаар ажилладаг байх ба шаардлага гарсан үед системийн ачааллыг хялбар шилжүүлдэг байх.

6.3.14. Зориулалтын виртуаль дэлгэц хуваагчтай байна. /сервер тус бүрээс заагдсан камеруудыг нэг дэлгэц дээр гаргах боломжтой/;

6.3.15. Системд олон оператор зэрэг хандаж ажиллах боломжтой байх;

6.3.16. Хөдөлгөөнт хэрэглэгч нь төв системээс мэдээлэл тайлан авах, системд алсын оператор горимоор оролцох, хяналтын камеруудыг удирдах, мөн шаардлага гарсан үед тухайн төхөөрөмжийн санах ойд байгаа бичлэгийг төв систем руу дамжуулах боломжтой байна.

6.3.17. Бодит дүрсийг 25 кадр/сек хурдтайгаар 32-оос доошгүй камерыг, бичлэг үзэхдээ 25 кадр/сек хурдтайгаар 20-оос доошгүй камерыг хардаг байх;

7. ТЕЛЕ ХЯНАЛТЫН СИСТЕМИЙН БАТАЛГАА

7.1. Системд ашиглагдаж байгаа тоног төхөөрөмж нь 24/7/365 тасралтгүй ажиллах ба дүрс хоцрох, тасалдах, хөдөлгөөнт камеруудыг удирдах үед гацахгүй байх шаардлагатай.

7.2. Аливаа эрсдэлийг урдчилан тооцсон байна.
7.3. Тоног төхөөрөмжийн баталгаа нь 3 жил, засвар, үйлчилгээний баталгаа 2 жил байна.

д/ д	Байршлын нэр		Камерын цэгийн нэр	Харах чиглэл	Чиглэлийн камер	Хөдөлгөөнт камер	Камерын шонгийн өндөр тоо
1	Хот дотор	Хөгжил хороолл	К-1	4 чиглэл		1	
2		Солонго хороолол	К-1	4 чиглэл		1	5м, 1ш
3		Солонго хороолол	К-1	4 чиглэл		1	5м, 1ш
4		Хөгжил хороллын 4 замын уулзвар	К-2	4 чиглэл		1	
5		Уран хотхон	К-3	4 чиглэл		1	5м, 1ш
6		Дэвшил 33-р байрны цэг	К-4	2 чиглэлд	1		
7		Мандал Голомт Зуух-2 урд талд	К-5	4 чиглэл		1	5м, 1ш
8		1-р сургуулийн баруун хойд талд	К-6	4 чиглэл		1	
9		Нарлаг хороолол гүний худгийн ар талд	К-7	4 чиглэл		1	
10		17, 19-р байрны зүүн урд	К-8	2чиглэлд	1		
11		1, 2-р байрны хойт талд	К-9	4 чиглэл		1	5м, 1ш
12		Мон-Алтай 1 төвийн зүүн урд тал	К-10	4 чиглэл		1	5м, 1ш
13		21, 22-р байрны урд тал	К-11	2 чиглэл	1		
14		Насан туршийн болосрол, Хуучин номын сангийн дунд	К-12	4 чиглэл		1	5м, 1ш
15		ШШГГ, 10-р цэцэрлэгийн дунд	К-13	4 чиглэл		1	5м, 1ш
16		30-р байрны зүүн урд талд	К-14	4 чиглэл		1	5м, 1ш
17	Хотын захад	Баяншанд баг Тотал төвийн зүүн урд	К-15	4 чиглэл		1	8-10м, 1ш
18		Баяншанд баг цэнхэр хашааны эхэнд	К-16	4 чиглэл		1	8-10м, 1ш
19		Баянхайрхан баг 9-р гудамны эхэнд	К-17	4 чиглэл		1	8-10м, 1ш
20		Жаргалант баг Тоосгоны	К-18	4 чиглэл		1	8-10м, 1ш

		үйлдвэрийн ар талд					
21		Харзат баг Цэвэрлэх байгууламжийн хажууд	К-19	4 чиглэл		1	8-10м, 1ш
Нийт дүн					**3**	**18**	**14**

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ-2

/Онцгой объект болох Ундарга Алтай ААТҮГ-ын ундны усны гүний худаг, нөөцийн усан санд хяналтын камер суурилуулах/

8. ТЕХНИКИЙН ЕРӨНХИЙ ШААРДЛАГА.

8.1. Монгол улсын **MNS 6423:2013** стандартыг мөрдлөг болгоно.

8.2. **Телех-хяналтын систем нь:** Дараах бүтэцтэй байна.

i. Телекамер;
j. Бичлэг хадгалах төхөөрөмж;
k. Бичлэгийн програм хангамж;
l. Хяналтын дэлгэц;
m. Сүлжээний төхөөрөмжүүд;
n. Цахилгаан тэжээлийн төхөөрөмж;
o. Сүлжээний болон цахилгааны холболт зэргээс бүрдэнэ.

8.3. Телехяналтын системд ашиглагдаж байгаа техник хэрэгслийн баталгаат хугацаа 3 жилээс багагүй байх.

8.4. Камерын системд гадна ажиллах бүхий л тоноглол нь Монгол орны цаг уур, орчинд тохирсон (-)40С – (+)50С ажилладаг, чийгшилт, тоосжилтын хамгаалалттай байна.

8.5. Угсралт монтажын ажлыг холбогдох стандарт шаардлагын дагуу чанарын өндөр түвшинд гүйцэтгэсэн байна.

9. СҮЛЖЭЭНИЙ ХОЛБОЛТ:

9.1. Хяналтын камерын системийн сүлжээг шаардлага, техникийн нөхцөлийн дагуу зохион байгуулах бөгөөд сүлжээг тухайн нутаг дэвсгэрт байрлах усан сан, гүний худгийн байранд суурилуулахаар зохион байгуулна.

9.2. Сүлжээг LAN сүлжээгээр холбосон байна.

10. СҮЛЖЭЭНИЙ ШААРДЛАГА:

10.1. Сүлжээний үндсэн төхөөрөмжүүд нь Gigabit Ethernet сүлжээний төхөөрөмж байна.

10.2. Сүлжээний хамгаалалтын түвшинг нэмэгдүүлэх LAN үүсгэх L2 түвшний төхөөрөмжүүд байна.

10.3. Сүлжээний төхөөрөмжүүд нь тухайн сүлжээний хяналтын камерын урсгалыг даахуйц үзүүлэлттэй, тасалдалгүй дамжуулдаг байх;

10.4. Сүлжээний дэд бүтэц байгуулах төлөвлөгөө, шийдлийг боловсруулж инженерийн дэлгэрэнгүй зураг, тайлбартай гаргасан байна.

11. ТЕЛЕХЯНАЛТЫН СИСТЕМИЙН ШУГАМЫН МОНТАЖ, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ХОЛБОЛТ, УГСРАЛТ СУУРИЛУУЛАЛТ

11.1. Угсралт, суурилуулалтын ерөнхий шаардлага

Хяналтын системийн дүрсний, тэжээлийн, удирдлагын, сүлжээний зэрэг холболтын кабель, шугамын монтажийг барилга дотор болон гадна татагдахаас хамаарч дараах байдлаар хийнэ. Үүнд:

11.1.1. Камерын сүлжээг Монгол Улсын MNS:5207:2011стандартын дагуу хийж

гүйцэтгэх.

11.1.2. Барилга доорхи монтажийг кабель далдлагч ашиглах бөгөөд кабелийн тоо хэмжээнээс хамаарч далдлагчийн хэмжээ багтаамжийг сонгох.

11.1.3. Далдлагчийг тухайн барилгын хийц, онцлог, зохион байгуулалтаас хамаарч хана болон таазанд суурилуулах;

11.1.4. Гадаа татагдах кабель шугамыг уян хоолойгоор далдлаж, газраас дээш 3 метрээс доошгүй өндөрт бэхэлсэн байх, энэ үед кабелийн өнгө үзэмжийг анхаарч бэхэлгээг хийх шаардлагатай. Бэхэлгээ хийхэд хамгаалалтын хоолойн зориулалтын тогтоогчийг ашиглах;

11.1.5. Гэрээнд ажил дуусгавар болгох хугацааг эцэслэн тодорхой зааж өгөх;

12. ТЕЛЕКАМЕРЫН ТЕХНИКИЙН ШААРДЛАГА

12.1. <u>Камерын ерөнхий шаардлага</u>

12.1.1. Хяналтын камер нь олон улсын стандартад нийцсэн, дэлхийд хүлээн зөвшөөрөгдсөн бүтээгдэхүүн байна;

12.1.2. Тоон технологи дээр суурилсан байх;

12.1.3. Хяналтын цэгийн байрлал тухайн орчны гэрэлтүүлэг, онцлог байдлаас хамаарч хөдөлгөөнт эргэдэг /Pan-Tilt/, татдаг /Zoom/ камертай бусад төрлийн камеруудыг хосолсон байдлаар суурилуулна;

12.1.4. Олон улсын сүлжээний хяналтын камерын нэгдсэн стандарт болох ONVIF стандартыг дэмждэг байх.

12.1.5. Ус чийг, тоос, шороо, доргилтоос хамгаалагдсан IP66 болон NEMA 4X rated, IK-10 зэрэг олон улсын стандарт шаардлагуудыг заавал хангасан байх.

12.1.6. Камерийн бичигч ажиллахгүй болсон үед камер нь өөрийн 64GB SDXC дээр бичлэгийг хадгалж, сүлжээ эргэж сэргэхэд бичлэгийг автоматаар /бичигчид/ дамжуулдаг байх ба бичигч нь хамгийн багадаа 6 сарын бичлэг хадгалах багтаамжтай байна.

12.1.7. Хяналтын цэгийн байрлал тухайн орчны гэрэлтүүлэг, онцлог байдлаас хамаарч маш бага гэрлийн орчинд дүрсний чанар өндөртэй, хөдөлгөөнт эргэдэг татдаг камертай бусад төрлийн камеруудыг хосолсон байдлаар суурилуулж болно.

12.1.8. Дүрс хувиргаж сүлжээнд дамжуулах шахалтын горим нь лицензтэй H.265,IR5, (ISO/IEC 14496-10), Motion JPEG (M-JPEG) байх;

12.2. <u>Хөдөлгөөнт эргэдэг теле камерын шаардлага:</u>

12.2.1. Эргэдэг татдаг камер байх;

12.2.2. Оптик таталт 30х, тоон таталт 12х, таталтын нийт хэмжээ 360х дахин (түүнээс дээш) байх;

12.2.3. Дүрсний хэмжээс, нягтрал: 1280x720, HD 720p ба түүнээс дээш байх;

12.2.4. Нэг секундэд авах кадрын тоо нь дүрсний бүх хэмжээсд 25-30 кадр байх;

12.2.5. Хамгийн багадаа 4ш бие даасан H.265 урсгалтай байх бөгөөд дараах зориулалтаар тус бүрийн хэрэглээний онцлогт нь тааруулж тохируулах боломжтой байх. (Оператор, Бичлэгийн сервер, SDXC Нөөц бичлэг, Зайн хандалт болон бусад хэрэглээ.)

12.2.6. Хэт улаан гэрэл (IR-Infra Red) дэмждэг, линзэндээ хэт улаан гэрлийн автомат хөшигтэй байх;

12.2.7. Ажиллах хамгийн бага гэрлийн орчин нь: Хар цагаан горимд – 0.01 люкс, өнгөт горимд – 0.1 люкс;

12.2.8. Хүйтний улиралд цахилгааны саатлаас болж төхөөрөмж хөлдөх эрсдэлтэй. Цахилгаан сэргэхэд камер өөрийгөө хэвийн ажиллах температур хүртэл халаасны дараа асдаг байх;

12.2.9. Байгалийн гэрлийн орчинд тохирч ажиллах, өдөр шөнийн автомат функцтэй байх

12.2.10. Харанхуй орчинд дүрсийг сайн таних, хөдөлгөөнд ямар нэгэн сарнил (30 кадраас буухгүй) байхгүй байх.

12.3. <u>Чиглэлийн теле камерын шаардлага:</u>

12.3.1. Хөдөлгөөнгүй камер байна;
12.3.2. Дүрсний нягтрал HD1080 ба түүнээс дээш байх;
12.3.3. Секундэд авах кадрын тоо нь дүрсний бүх хэмжээсд 25-30 кадр байна;
12.3.4. 2.8-8мм эсвэл түүнээс дээш, 800-350 харах чадвартай, автомат DC-Iris, камерын фокусыг хяналтын төвөөс систем дээрээс тохируулдаг байна;
12.3.5. Хэт улаан гэрэл (IR-Infra Red) дэмждэг, линзэндээ хэт улаан гэрлийн автомат хөшигтэй байна;
12.3.6. Харанхуйд хөдөлгөөний зууралтгүй, өнгөтөөр харах камерын урдаас туссан шууд гэрлийн нөлөөний эсрэг функцтэй байх - Wide Dynamic Range
12.3.7. Камерын тусгал, фокус ба чиглэл өөрчлөгдсөн үед автоматаар түгшүүр зарладаг
12.3.8. Ажиллах гэрлийн орчин нь: Хар цагаан горимд – 0.02 люкс, өнгөт горимд – 0.1 люкс;
12.3.9. Байгалийн гэрлийн орчинд тохирч ажиллах, өдөр шөнийн автомат функцтэй байна.
12.3.10. Харанхуй орчинд дүрсийг өнгөтөөр таних, хөдөлгөөнд ямар нэгэн сарнил (30 кадраас буухгүй) байхгүй байна.
12.3.11. Бага гэрлийн орчинд хөдөлгөөнийг мэдэрч ямарч сарнил, гацалт, хөдөлгөөний зууралт үүсэхгүй байна;

13. ТЕЛЕ ХЯНАЛТЫН СИСТЕМИЙН БАТАЛГАА

13.1. Системд ашиглагдаж байгаа тоног төхөөрөмж нь 24/7/365 тасралтгүй ажиллах ба дүрс хоцрох, тасалдах, гацахгүй байх шаардлагатай.
13.2. Аливаа эрсдэлийг урдчилан тооцсон байна.
13.3. Тоног төхөөрөмжийн баталгаа нь 3 жил, засвар, үйлчилгээний баталгаа 2 жил байна.

Д/Д	Байршлын нэр		Координат	Камерын цэгийн нэр	Харах чиглэл	Гадна камер	Дотор камер
1	Харзат баг	Нөөцийн усан сан 1		К-1	4 чиглэл	Эргэдэг камер 1	1
2		Нөөцийн усан сан 2		К-2	4 чиглэл	Эргэдэг камер 1	1
3		Харзат гүний худаг 1	46.3205.814 N 96.34806E	К-3	1 чиглэл	2	1
4		Харзат гүний худаг 2	46.3197222 96.34583	К-4	1 чиглэл	2	1
5		Харзат гүний худаг 3	46.3208333 96.34806	К-5	1 чиглэл	2	1
6		Харзат гүний худаг 4	46.34 96.31669	К-6	1 чиглэл	2	1
7		Харзат гүний худаг 5	46.3480556 96.29139	К-7	1 чиглэл	2	1
8		Харзат гүний худаг 6	46.3388889 96.275	К-7	1 чиглэл	2	1

Тав. **ЗУРАГ**

Багц-1 /Хяналтын камер суурилуулах ажил/

Зураг 1. Метал шонгийн зураг



Зураг 2. Метал шонгийн суурь



Зураг 3. Антеннтай камер суурилуулах зураг



АЖЛЫН ТОО ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ

ХЯНАЛТЫН КАМЕРИЙН АЖИЛ

Д/Д	Ажлын нэр	Нэгж	Тоо хэмжээ
1	TND1 (SVC)-5 маягийн хүчдэл тогтворжуулагч	шир	8
2	Тоос, чийгний хамгааалалттай гадна хяналтын камер суурилуулах	иж бр	18
3	Дотор талын хяналтын камер угсрах, 4MP, Full HD, IP67	ш	8
4	100/1000GB хурд дамжуулах, 8 port-той свич угсрах	1	8
5	NVR бичигч	шир	8
6	Ажиглалтын дэлгэц (17 инчийн LED дэлгэц)	ш	8
7	Тусгай тусгаарлагчтай гадна кабель суурилуулах	1метр	350

ХОТЫН ГАДНА БҮСИЙН ХЯНАЛТЫН КАМЕРИЙН АЖИЛ

Д/Д	Ажлын нэр	Нэгж	Тоо хэмжээ
1	TND маягийн хүчдэл тогтворжуулагч блок	шир	5
2	IR PTZ Camera Outdoor хяналтын камер	шир	21
3	WIreless LInk outdoor	шир	3
4	WIreless brIdje 802.11n, 1x10/100Mbps	шир	22
5	Poe SwItch агаарын залгуур салгуур	шир	1
6	Camera pole-дагалдах хэрэгслийн хамт	ком	5
7	EguIpment box (Хуваарилах хайрцаг) угсрах, IP66	ш	21
8	AC cable- кабель 2*10 A WG	м	500
9	DIsplay 42" Inch IPS LED Full ND (1080p)	шир	1
10	Recorder 32 Channel, PPPoE, DDNS	шир	1
11	2 фазын энгийн цахилгааны тоолуур угсрах	ш	21

ГАДНА КАМЕРИЙН ШОНГИЙН АЖИЛ

Д/Д	Ажлын нэр	Нэгж	Тоо хэмжээ
1	1.2м хүртэл гүн шонгийн нүх 3-р зэргийн хөрсөнд гараар ухах	м3	0.936
2	Төмөр баганын бетон суурь цутгах	м3	3.15
3	Гадна талбайн камерийн төмөр шон угсрах	ш	6
4	3-р зэргийн хөрсийг түрж хүнхэл ба шуудууг булах	м3	3

Зургаа. **ЖИШИГ МАЯГТ**

ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга_____танаа

1. Бид, *[**тендерт оролцогчийн нэр**], [**гэрээний нэр ба дугаар**]*-ыг *[**тендерийн үнийг тоогоор болон үсгээр**]* төгрөгөөр тендерийн баримт бичгийн дагуу гүйцэтгэхээр санал болгож байна.

2. Тендер нь тендерийн баримт бичигт заасны дагуу тендер хүлээн авах эцсийн хугацаанаас хойш ***30*** хоногийн хугацаанд хүчинтэй байх ба та энэ хугацаа дуусахаас өмнө түүнийг сонгох боломжтой.

3. Гэрээг албан ёсоор байгуулах хүртэл энэхүү тендер болон түүнийг шалгарсан тохиолдолд гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл нь бидний хооронд хийгдсэн хэлцэл болно.

4. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

Долоо. **ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ**

1. Гүйцэтгэгч ажил гүйцэтгэх

1.1. Гүйцэтгэгч гэрээний тусгай нөхцөлд заасан ажлыг техникийн тодорхойлолт болон зургийн дагуу хийж гүйцэтгэнэ.

2. Төслийн менежерий н шийдвэр

2.1. Гэрээнд тусгайлан заагаагүй бол гэрээтэй холбогдсон аливаа асуудлыг захиалагчийг төлөөлөн төслийн менежер шийдвэрлэнэ.

3. Ажил дуусгахаар төлөвлөсө н өдөр ажил дууссан байх

3.1. Гүйцэтгэгч ажлыг гэрээний тусгай нөхцөлд заасан өдөр эхлүүлж, өөрийн гаргасан ажлын хөтөлбөр болон төслийн менежерийн баталсан тодотгосон ажлын хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэн, ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр дуусгана.

4. Аюулгүй байдал

4.1. Гүйцэтгэгч ажлын талбай дээрх бүх үйл ажиллагааны аюулгүй ажиллагааг хангаж ажиллана.

4.2. Барьж байгаа барилга, байгууламжаа байгалийн болзошгүй гамшиг, гэнэтийн аюулаас хамгаалах бүх талын арга хэмжээг авч, өөрийн нь ажилтай холбогдуулж барилгын болон байгаль орчин, эрүүл ахуй, гал түймрийн хяналтын албанаас гаргасан хууль ёсны шаардлага, дүгнэлтийг хүлээн авч биелүүлнэ.

5. Зааварчилг аа

5.1. Төслийн менежерийн гаргах аливаа зааварчилгаа нь Монгол улсын хууль, тогтоомжид нийцсэн байх бөгөөд түүнийг гүйцэтгэгч биелүүлэх үүрэгтэй

6.Маргааныг шийдвэрл э х

6.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.

Б. ХУГАЦААНЫ БОЛОН ЧАНАРЫН ХЯНАЛТ

7. Ажлын хөтөлбө р

7.1. Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэхэд шаардлагатай бүх үйл ажиллагааны ерөнхий аргачлал, зохион байгуулалт, дэс дараалал, ажил гүйцэтгэх хугацаа болон бусад шаардлагатай мэдээллийг тусгасан ажлын хөтөлбөрийг боловсруулж, гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд төслийн менежерт хүргүүлж батлуулна.

7.2. Ажлын хөтөлбөрийг төслийн менежер батлах нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Гүйцэтгэгч нь ажлын хөтөлбөрийг хянан засварлаад төслийн менежерт хэдийд ч дахин хүргүүлж болно. Хянан засварласан ажлын хөтөлбөрт өөрчлөлтийг тусгана.

8. Зөрчил, гологдо л илрүүлэх

8.1. Төслийн менежер гүйцэтгэгчийн ажлыг шалгаж, илэрсэн зөрчил, гологдлын талаар түүнд мэдэгдэнэ. Энэхүү шалгалт нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй.

Төслийн менежер зөрчил, гологдол байж болзошгүй гэж үзсэн аливаа ажилд зөрчил, гологдол хайх, уг ажлын далд хэсгийг нээж шалгалт, туршилт явуулах талаар зааварчилгааг гүйцэтгэгчид өгөх эрхтэй.

9. Зөрчил, гологдол арилгах

9.1. Төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан чанарын баталгаат хугацаа [2] дуусахаас өмнө зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдлийг гүйцэтгэгчид өгнө. Чанарын баталгаат хугацааг зөрчил, гологдлыг арилгаж дуусах хүртэл сунгана.

9.2. Зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдэл өгсөн тухай бүр гүйцэтгэгч уг зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж өөрийн зардлаар арилгана.

10. Зөрчил, гологдол арилгахгүй байх

10.1. Хэрэв гүйцэтгэгч зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж арилгаагүй бол төслийн менежер зөрчил, гологдол арилгахад шаардагдах зардлыг тооцож гүйцэтгэгчээс гаргуулна.

В. ЗАРДЛЫН ХЯНАЛТ

11. Үе шатны ажлын хуваарь

11.1. Төслийн менежерийн шаардсаны дагуу гүйцэтгэгч үе шатны ажлын тодотгосон хуваарийг 14 хоногийн дотор бэлтгэж ирүүлнэ. Үе шатны ажлын хуваарьт тусгагдсан үйл ажиллагаа нь ажлын хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагаатай нийцсэн байна.

11.2. Ажлын талбай дахь материалын төлбөрийг тусад нь хийх бол гүйцэтгэгч ажлын талбайд нийлүүлсэн материалын тооцоог үе шатны ажлын хуваариас тусад нь гаргаж ирүүлнэ.

12. Үе шатны ажлын хуваарийг өөрчлөх

12.1. Гүйцэтгэгчийн шийдвэрээр ажлын арга барил, эсхүл ажлын хөтөлбөрт гарсан өөрчлөлтийг тусгах зорилгоор гүйцэтгэгч үе шатны ажлын хуваарьт нэмэлт өөрчлөлт хийнэ. Өөрчлөлт хийхдээ үе шатны ажлын хуваарь дахь үнийг өөрчлөхгүй.

13. Алданги

13.1. Гүйцэтгэгч нь ажил дуусгахаар төлөвлөсөн өдрөөс хугацаа хоцорсон хоног тутамд гэрээний тусгай нөхцөлд заасан хувь хэмжээгээр алданги [3] төлнө. Алдангийн нийт дүн гэрээний тусгай нөхцөлд заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. Захиалагч нь алдангийг гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс суутган авч болно. Алданги төлсөн нь гүйцэтгэгчийн хүлээсэн үүрэг хариуцлагыг хөндөхгүй.

Г. ГЭРЭЭГ ДУУСГАХ

14. Ажил

14.1. Гүйцэтгэгч нь ажил дууссан тухай мэдэгдэл гаргах

---

[2] Чанарын баталгаат хугацааг тогтоохдоо Иргэний хууль болон Барилгын тухай хуулийг баримтална.

[3] Алдангийг ихэвчлэн хоногт 0.05-0.10 хувиар тогтоох бөгөөд нийт дүн нь гэрээний үнийн 5-10%-иас хэтрэх ёсгүй.

дуусгах

хүсэлтийг төслийн менежерт тавих бөгөөд төслийн менежер ажил дууссан гэж үзвэл уг мэдэгдлийг гаргана. Гүйцэтгэгч гадна тохижилтын ажлыг бүрэн дуусгаж, ажлын явцад гудамж, зам, талбай сэтэлж, мод, цэцэрлэгжүүлэлтийг түр зайлуулсан бол эдгээрийг бүрэн хэмжээгээр сэргээсэн байна.

15. Хүлээж авах

15.1.Төслийн менежер ажил дууссан тухай мэдэгдэл гаргаснаас хойш захиалагч долоо хоногийн дотор ажлын талбай болон ажлыг хүлээж авна.

16. Эцсийн тооцоо

16.1. Гүйцэтгэгч гэрээний дагуу төлөгдөх ёстой гэж үзэж буй нийт төлбөрийн нарийвчилсан тооцоог гаргаж, чанарын баталгаат хугацаа дуусахаас өмнө төслийн менежерт хүргүүлнэ.
Төслийн менежер зөрчил, гологдол арилгасан тухай мэдэгдэл гаргаж, хэрэв гүйцэтгэгчийн ирүүлсэн тооцоо бүрэн гүйцэд, үнэн зөв бол уг тооцоог хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор гүйцэтгэгчид төлөх эцсийн төлбөрийг тодорхойлно.
Хэрэв тооцоо буруу байвал шаардлагатай залруулга, нэмэлт өөрчлөлтийн талаарх тайлбарыг 14 хоногийн дотор гаргаж гүйцэтгэгчид хүргүүлнэ. Хэрэв засвар хийж дахин ирүүлсэн эцсийн тооцоо нь шаардлага хангаагүй бол төслийн менежер гүйцэтгэгчид төлөх дүнг шийдвэрлэж төлбөрийн мэдэгдэл гаргана.

17. Ашиглалт, засвар, үйлчилгээний гарын авлага

17.1. Гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийн зураг, далдлагдсан ажил, инженерийн шугам сүлжээ, технологийн тоног төхөөрөмжийг туршиж тохируулсан акт болон захиалагч шаардсан бол ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд хүлээлгэн өгнө.

17.2. Хэрэв гүйцэтгэгч 22.1-д заасан материалыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд ирүүлээгүй, эсхүл шаардлага хангаагүйн улмаас тэдгээрийг төслийн менежер батлаагүй бол гүйцэтгэгчид төлөх ёстой төлбөрөөс төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан үнийн дүнг суутгана.

18. Гэрээг цуцлах

18.1. Захиалагч, эсхүл гүйцэтгэгч нөгөө тал нь гэрээг ноцтой зөрчсөн гэж үзвэл гэрээг цуцлах эрхтэй.

18.2. Дор дурдсан нөхцөлүүдийг гэрээний ноцтой зөрчил гэж үзэх бөгөөд эдгээрээр хязгаарлагдахгүй:

(а) ажлын хөтөлбөрт ажил зогсоох тухай заагаагүй, түүнчлэн ажил зогсоох тухай шийдвэрийг төслийн менежер батлаагүй байхад гүйцэтгэгч ажлыг 28 буюу түүнээс дээш хоногийн хугацаагаар зогсоосон;

(б) төслийн менежер ажлын явцыг зогсоох зааварчилгааг гүйцэтгэгчид өгсөн бөгөөд уг шийдвэрээ 28 хоногийн дотор цуцлаагүй;

(в) захиалагч, эсхүл гүйцэтгэгч дампуурсан, эсхүл өөрчлөн байгуулагдах, нэгдэхээс бусад зорилгоор татан буугдсан;

(г) тодорхой зөрчил, гологдлыг арилгаж чадаагүй нь гэрээний ноцтой зөрчил болохыг төслийн менежер гүйцэтгэгчид мэдэгдсэн бөгөөд гүйцэтгэгч нь уг зөрчил, гологдлыг заасан хугацаанд нь багтаан арилгаж чадаагүй;

(д) гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийг гэрээний тусгай нөхцөлд заасан алдангийн дээд хэмжээ төлөх хугацаагаар хоцроосон.

18.3. Гэрээг цуцалсан тохиолдолд гүйцэтгэгч ажлыг даруй зогсоож, ажлын талбайн бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хангаж, түүнийг аль болох түргэн хугацаанд чөлөөлнө.

19. Гэрээг цуцалсан үед хийх төлбөр

19.1. Гүйцэтгэгч гэрээг ноцтой зөрчсөний улмаас гэрээ цуцлагдсан бол төслийн менежер гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээг нотолсон мэдэгдэл гаргана. Ингэхдээ мэдэгдэл олгосон өдөр хүртэл дуусаагүй ажлын гэрээний тусгай нөхцөлд заасан хэмжээг дээрх үнэлгээнээс хасна. Нэмэлт алданги гүйцэтгэгчид ногдуулахгүй.

19.2. Гэрээг захиалагчийн шаардлагаар, эсхүл гэрээг захиалагч ноцтой зөрчсөний улмаас цуцалсан бол гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээ,тоног төхөөрөмжийг ажлын талбайгаас гаргах бодит зардал, ажлын зорилгоор хөлслөн ажиллуулсан гүйцэтгэгчийн ажилтнуудыг буцаахтай холбогдсон зардал, түүнчлэн ажлыг хадгалах, хамгаалахтай холбогдсон зардал зэрэг гүйцэтгэгчийн зардлыг төслийн менежер хянаж мэдэгдэл гаргана.

20. Гүйцэтгэлэ эс чөлөөлөх

20.1. Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдлын улмаас гэрээг гүйцэтгэх боломжгүй болсон бол төслийн менежер үүнийг гэрчилнэ. Гүйцэтгэгч нь энэхүү мэдэгдлийг хүлээн авсны дараа ажлын талбайн бүрэн бүтэн байдлыг хангаж, ажлыг аль болох богино хугацаанд зогсооно. Захиалагч уг мэдэгдэл гарахаас өмнө хийгдсэн ажил болон түүний дараа захиалгаар гүйцэтгэсэн ажлын
хөлсийг гүйцэтгэгчид төлнө.

Найм. **ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ**[4]

ГЕН 2.1	Гэрээний нэр болон бүртгэлийн дугаар: *[***Алтай хотын нийтийн эзэмшлийн талбай, тусгай зориулалтын объектыг телекамерын хяналтын системтэй болгох , ГААЕБСЗДТГ/202101001***]*
ГЕН 2.1	Ажил нь *[***Алтай хотын нийтийн эзэмшлийн талбай, тусгай зориулалтын объектыг телекамерын хяналтын системтэй болгох***]*-аас бүрдэнэ. Ажлын талбай нь *[Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын нутаг дэвсгэр]*-д байрших ба техникийн тодорхойлолт болон зураг №1, 2-д зааснаар тодорхойлогдсон болно.
ГЕН 3.1	Төслийн менежер нь *[Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын Засаг даргын Тамгын газар]*
ГЕН 4.1	Ажил эхлэх өдөр *[гэрээ байгуулах эрх олгосон өдрөөс]* Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр *[2021.08.20*
ГЕН 7.1	Гүйцэтгэгч гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш *[5]* хоногийн дотор тодотгосон ажлын хөтөлбөрийг гаргана.
ГЕН 9.1	Чанарын баталгаат хугацаа *[3]* жил байна.
ГЕН 13.1	Алданги ногдуулах хэмжээ хоногт гэрээний үнийн *[0,05 хувь]* байна.[6]
	Нийт ажилд ногдуулах алдангийн дээд хэмжээ нь гэрээний үнийн *[10 хувь]* байна.
ГЕН 17.1	Ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг *[2021.08.01]*-ний дотор гаргаж өгнө.
	Гүйцэтгэлийн зургийг *[2021.08.01]*-ний дотор гаргаж өгнө.
	Гүйцэтгэлийн зургийг, эсхүл ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг хугацаанд нь гаргаж өгөөгүй тохиолдолд суутгах төлбөрийн хэмжээ *[500,000 төгрөг]* байна.
ГЕН 19.1	Ажил дуусгахад захиалагчаас гарах нэмэлт зардлыг дуусаагүй ажлын *[ ]*-иар тооцно.

4 Захиалагч тендерийн баримт бичгийг тараахаас өмнө гэрээний тусгай нөхцөлийг бүрэн бөглөсөн байна. Захиалагчийн гаргах хуваарь, тайланг гэрээний тусгай нөхцөлд хавсаргана.

5 Ажлыг хэсэгчлэн дуусгахаар төлөвлөсөн бол эдгээр хугацааг жагсаана.

6 Ажлыг хэсэг хэсгээр дуусгах болон хэсэг бүрт алданги хэрэглэх бол энд тусгана.

Ес. ГЭРЭЭНИЙ МАЯГТ

ЗАХИАЛАГЧ	**ГҮЙЦЭТГЭГЧ**
_____ (Тамга, тэмдэг)	_____ (Тамга, тэмдэг)
_____ (Гарын үсэг)	_____ (Гарын үсэг)
(Албан тушаал)	(Албан тушаал)

***[Тендер шалгаруулалт/гэрээний нэр]* гэрээ.**

Дугаар № *[Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]*

.....
хот/аймаг

Нэг талаас [захиалагчийн нэр] (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас [гүйцэтгэгчийн хот, улс, гүйцэтгэгчийн нэр] (цаашид “гүйцэтгэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож _____ оны _____ сарын_____-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний хууль, Барилгын тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу инженерийн хийцтэй барилга байгууламж барих, засварын ажил гүйцэтгэх, тоног төхөөрөмж суурилуулахтай холбогдон захиалагч, гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.

2. Захиалагч нь [гэрээний нэр, дугаар]-г (цаашид “ажил” гэх) [гэрээний үнийг тоогоор болон үсгээр] (цаашид “гэрээний үнэ” гэх) гүйцэтгэхээр ирүүлсэн гүйцэтгэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ буюу ажлын нийт төсөвт өртөг нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

3. Гэрээний нийт дүн:_____төгрөг. Үүнээс:

Улсын төсвөөс: 20…. онд:_____төгрөг; 20…. онд:_____төгрөг;

4. Гүйцэтгэгч нь _____байршилтай _____ хүчин чадал бүхий_____ам.метр талбай/_____шоо метр эзлэхүүн/-тай,_____суурь, _____ хана, _____ хучилттай, _____ давхар _____барилга угсралт /барилгын засвар, тоног төхөөрөмж суурилуулах/-ын ажлыг _____инженерийн шугам сүлжээ /дулаан, цахилгаан, цэвэр, бохир усан хангамж/,_____туслах барилга /бусад ажил/-ын хамт_____оны_____дугаар сарын_____-ны өдөр эхэлж, _____оны_____дугаар сарын_____-ны өдөр ашиглалтад оруулна.

5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

5.1. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
5.2. Бусад шаардлагатай баримт бичиг ;
5.3. Үнийн санал
5.4. Гэрээний тусгай нөхцөл;
5.5. Гэрээний ерөнхий нөхцөл;
5.6. Техникийн тодорхойлолт;
5.7. Зураг;
5.8. Гүйцтгэгчийн ирүүлсэн үе шатны ажлын хуваарь :
5.9. Санхүүжилтийн хуваарь;
5.10. Ажил гүйцэтгэх хуваарь.

Гэрээ нь энд дурдсан ажлыг гүйцэтгэх талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний бичиг баримтууд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дараалын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Захиалагч, гүйцэтгэгч нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх, үүрэг хүлээнэ.

7. Гүйцэтгэгч нь гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан ажлыг гүйцэтгэж, зөрчил, гологдол арилгах үүрэг хүлээнэ.

8. Захиалагч нь гэрээний дагуу гүйцэтгэгчийн хийх ажил болон зөрчил, гологдол арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний төлбөрийг гүйцэтгэгчид төлөх үүрэг, хүлээнэ.

9. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр болон утсан холбоогоор харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:	**ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**
[Албан тушаал, нэр]	*[Албан тушаал, нэр]*
*[Гарын үсэг]*_____	*[Гарын үсэг]*_____
ТАМГА	ТАМГА
[Захиалагчийн хаяг]	*[Захиалагчийн хаяг]*
[Утас/факсын дугаар]	*[Утас/факсын дугаар]*
[Харилцагч банкны нэр, дансны дугаар	*[Харилцагч банкны нэр, дансны дугаа*